

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ШУА	Шинжлэх Ухааны Академи
МУ	Монгол Улсын
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....</b>	<b>12</b>
3.Аудитын тайлан .....	13
3.1. Ерөнхий зүйл .....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9 Аудитын илрүүлэлт .....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын Зөвлөмж .....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ОДОН ОРОН ГЕОФИЗИКИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ  
С.ДЭМБЭРЭЛ ТАНАА

2021.02.25 № 07/598  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>38,101,895.25</u></b>	<b><u>176,851,520.19</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	97,123,978.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	97,123,978.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	97,123,978.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	97,123,978.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	15,779.52	43,136,338.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,779.52	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	43,136,338.06
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	38,086,115.73	36,591,204.13
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	36,591,204.13	36,591,204.13
35110	Тусгай зориулалттай материал	36,591,204.13	36,591,204.13
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,494,911.60	-
35410	Бичиг хэргийн материал	441,541.60	-
35420	Аж ахуйн материал	1,053,370.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,213,735,422.75</u></b>	<b><u>6,464,603,433.57</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,213,735,422.75	6,464,603,433.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,112,842,241.05	5,426,606,348.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,456,496,709.94	3,620,954,387.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	214,330,942.91	320,560,115.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	196,142,987.28	127,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	116,897,154.03	34,849,166.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,788,094,169.65	3,701,508,329.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	3,042,848,000.36	1,714,978,576.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,349,037.00	129,404,842.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	78,932,130.73	85,640,916.55
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,300,000.00	1,300,000.00
39217	Ном	2,467,565.21	2,467,565.21
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,100,893,181.70	1,037,997,085.25
39301	Программ хангамж	655,565,637.00	632,770,571.57
39302	Хуримтлагдсан элэгдэл	333,362,055.30	373,463,086.32
39303	Бусад биет бус хөрөнгө	796,229,600.00	778,689,600.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	17,540,000.00	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5,251,837,318.00</u></b>	<b><u>6,641,454,953.76</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>6,400,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	6,400,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	6,400,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	6,400,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	6,400,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>5,251,837,318.00</u></b>	<b><u>6,635,054,953.76</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,251,837,318.00	6,635,054,953.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,889,184,696.66	2,889,184,696.66
51101	Өмч: - төрийн	2,889,184,696.66	2,889,184,696.66
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,366,363,332.69	2,749,580,968.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,366,363,332.69	1,366,363,332.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,383,217,635.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	996,289,288.65	996,289,288.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>5,251,837,318.00</u></b>	<b><u>6,641,454,953.76</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,476,121,538.51</b>	<b>7,905,587,499.11</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>116,830,548.35</b>	<b>3,759,087,120.88</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	116,830,548.35	3,759,087,120.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	116,830,548.35	3,759,087,120.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,890,548.35	2,084,713,228.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,940,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,000,000.00	1,674,373,892.88
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,359,290,990.16</b>	<b>4,146,500,378.23</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	3,103,177,600.00	3,833,310,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,103,177,600.00	3,833,310,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	256,113,390.16	312,938,354.69
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	72,944,990.16	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,763,700.00	62,636,175.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,404,700.00	250,302,179.69
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	251,223.54
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	251,223.54
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,954,749,183.69</b>	<b>6,522,369,863.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,954,749,183.69</b>	<b>6,522,369,863.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,944,489,584.27	6,265,105,811.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,895,693,291.68	2,299,923,317.44
210101	Үндсэн цалин	1,696,791,662.77	1,784,713,197.97
210102	Нэмэгдэл	144,032,920.91	252,187,320.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,911,100.00	229,796,400.00
210104	Урамшуулал	2,527,400.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	31,430,208.00	33,226,399.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	238,908,328.02	290,678,995.46
210201	Тэтгэврийн даатгал	167,233,721.73	200,378,045.04
210202	Тэтгэмжийн даатгал	17,924,500.00	22,705,405.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,316,306.29	17,200,954.95
210204	Ажилгүйдлийн даатгал	3,584,900.00	5,094,356.99
210205	Эрүүл мэндийн даатгал	35,848,900.00	45,300,233.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	224,533,710.18	209,432,849.36
210301	Гэрэл, цахилгаан	154,767,312.74	154,780,597.35
210302	Түлш, халаалт	56,498,828.55	46,654,644.61
210303	Цэвэр, бохир ус	13,267,568.89	7,997,607.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	77,162,217.40	73,620,884.61
210401	Бичиг хэрэг	16,199,989.00	4,176,341.60
210402	Тээвэр, шатахуун	5,274,666.59	11,165,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,481,261.81	36,402,354.01
210404	Ном, хэвлэл	7,684,025.00	7,249,075.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,005,632.00	971,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,516,643.00	13,656,604.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	88,463,183.00	124,039,885.25
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,061,183.00	38,992,513.65
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	38,402,000.00	80,047,371.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	138,250,009.72	129,343,970.63

210702	Дотоод албан томилолт	138,250,009.72	129,343,970.63
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>753,779,921.97</b>	<b>624,136,726.28</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	747,066,509.97	585,298,001.28
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	6,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	722,500.00	582,462.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	435,912.00	478,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	110,000.00
210807	Газрын төлбөр	2,000,000.00	31,267,351.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>527,698,922.30</b>	<b>2,513,929,182.06</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,837,629,305.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,142,700.00	1,008,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	511,556,222.30	675,291,877.06
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,259,599.42</b>	<b>257,264,052.26</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>4,642,131.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	4,642,131.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,998,810.00</b>	<b>4,215,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,998,810.00	4,215,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>260,789.42</b>	<b>248,406,921.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,168.69	247,855,615.77
113305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	181,620.73	551,305.49
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(478,627,645.18)</b>	<b>1,383,217,635.76</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(478,627,645.18)</b>	<b>1,383,217,635.76</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөс/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,475,121,538.51</b>	<b>6,230,962,382.69</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>115,830,548.35</b>	<b>2,084,713,228.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>115,830,548.35</b>	<b>2,084,713,228.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,830,548.35	2,084,713,228.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,890,548.35	2,084,713,228.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,940,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,359,290,990.16</b>	<b>4,146,249,154.69</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,103,177,600.00</b>	<b>3,833,310,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,103,177,600.00	3,833,310,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>256,113,390.16</b>	<b>312,938,354.69</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	72,944,990.16	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,763,700.00	62,636,175.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,404,700.00	250,302,179.69
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,415,545,621.51</b>	<b>5,882,052,409.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,415,545,621.51</b>	<b>5,882,052,409.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,405,286,022.09</b>	<b>5,581,652,019.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,895,693,291.68</b>	<b>2,299,923,317.44</b>
210101	Үндсэн цалин	1,696,791,662.77	1,784,713,197.97
210102	Нэмэгдэл	144,032,920.91	252,187,320.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,911,100.00	229,796,400.00
210104	Урамшуулал	2,527,400.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	31,430,208.00	33,226,399.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>238,924,107.54</b>	<b>290,411,992.40</b>



210201	Тэтгэврийн даатгал	167,249,501.25	200,111,041.98
210202	Тэтгэмжийн даатгал	17,924,500.00	22,705,405.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,316,306.29	17,200,954.95
210204	Ажилгүйдлийн даатгал	3,584,900.00	5,094,356.99
210205	Эрүүл мэндийн даатгал	35,848,900.00	45,300,233.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>215,107,710.18</b>	<b>209,432,849.36</b>
210301	Гэрэл, цахилгаан	154,767,312.74	154,780,597.35
210302	Түлш, халаалт	47,072,828.55	46,654,644.61
210303	Цэвэр, бохир ус	13,267,568.89	7,997,607.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>68,746,998.00</b>	<b>72,125,973.01</b>
210401	Бичиг хэрэг	8,309,149.60	3,734,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,274,666.59	11,165,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,481,261.81	36,402,354.01
210404	Ном, хэвлэл	7,684,025.00	7,249,075.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,005,632.00	971,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,992,263.00	12,603,234.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>78,140,883.00</b>	<b>124,039,885.25</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,738,883.00	38,992,513.65
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	38,402,000.00	80,047,371.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>138,250,009.72</b>	<b>129,343,970.63</b>
210702	Дотоод албан томилолт	138,250,009.72	129,343,970.63
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>754,280,321.97</b>	<b>617,736,726.28</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	747,566,909.97	585,298,001.28
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	722,500.00	582,462.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	435,912.00	478,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	110,000.00
210807	Газрын төлбөр	2,000,000.00	31,267,351.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,142,700.00</b>	<b>1,838,637,305.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,837,629,305.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,142,700.00	1,008,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,259,599.42</b>	<b>300,400,390.32</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>4,642,131.00</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	4,642,131.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,998,810.00</b>	<b>4,215,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,998,810.00	4,215,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>260,789.42</b>	<b>291,543,259.32</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,168.69	247,855,615.77
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	181,620.73	43,687,643.55
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>59,575,917.00</u></b>	<b><u>348,909,973.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>39,478.89</b>	<b>-</b>
140007	Хүлээн авсан хүүний орлого	39,478.89	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>59,575,917.00</b>	<b>251,785,995.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>59,575,917.00</b>	<b>251,785,995.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>59,575,917.00</b>	<b>251,785,995.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,575,917.00	251,785,995.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(59,536,438.11)</u></b>	<b><u>(251,785,995.00)</u></b>

	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	97,123,978.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	97,123,978.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,889,184,696.66	996,289,288.65	1,844,990,977.87	<b>5,730,464,963.18</b>
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	2,889,184,696.66	996,289,288.65	1,844,990,977.87	<b>5,730,464,963.18</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(478,627,645.18)	<b>(478,627,645.18)</b>
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,889,184,696.66	996,289,288.65	1,366,363,332.69	<b>5,251,837,318.00</b>
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	2,889,184,696.66	996,289,288.65	1,366,363,332.69	<b>5,251,837,318.00</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,383,217,635.76	<b>1,383,217,635.76</b>
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,889,184,696.66</b>	<b>996,289,288.65</b>	<b>2,749,580,968.45</b>	<b>6,635,054,953.76</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,833,310,800.00	3,585,455,184.23	247,855,615.77	93.53
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,833,310,800.00	3,585,455,184.23	247,855,615.77	93.53
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,824,448,800.00	3,576,598,053.23	247,850,746.77	93.52
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,434,424,600.00	2,266,696,917.97	167,727,682.03	93.11
210101	Үндсэн цалин	1,837,768,600.00	1,784,713,197.97	53,055,402.03	97.11
210102	Нэмэгдэл	300,976,000.00	252,187,320.00	48,788,680.00	83.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	295,680,000.00	229,796,400.00	65,883,600.00	77.72
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	334,182,200.00	286,278,668.40	47,903,531.60	85.67
210201	Тэтгэврийн даатгал	235,165,300.00	195,977,717.98	39,187,582.02	83.34
210202	Тэтгэмжийн даатгал	24,754,200.00	22,705,405.01	2,048,794.99	91.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,803,400.00	17,200,954.95	2,602,445.05	86.86
210204	Ажилгүйдлийн даатгал	4,950,800.00	5,094,356.99	(143,556.99)	102.90
210205	Эрүүл мэндийн даатгал	49,508,500.00	45,300,233.47	4,208,266.53	91.50
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	207,308,800.00	205,743,270.36	1,565,529.64	99.24
210301	Гэрэл, цахилгаан	106,585,100.00	151,091,018.35	(44,505,918.35)	141.76
210302	Түлш, халаалт	91,338,500.00	46,654,644.61	44,683,855.39	51.08
210303	Цэвэр, бохир ус	9,385,200.00	7,997,607.40	1,387,592.60	85.22
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	49,838,800.00	47,540,755.82	2,298,044.18	95.39
210401	Бичиг хэрэг	2,734,800.00	2,734,800.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	8,548,800.00	7,665,510.00	883,290.00	89.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,510,000.00	25,607,180.82	902,819.18	96.59
210404	Ном, хэвлэл	5,263,700.00	5,263,475.00	225.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,482,700.00	971,000.00	511,700.00	65.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,298,800.00	5,298,790.00	10.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	160,484,400.00	160,483,525.60	874.40	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	77,853,600.00	77,853,210.00	390.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	77,630,800.00	77,630,315.60	484.40	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	47,226,800.00	46,593,122.00	633,678.00	98.66
210702	Дотоод албан томилолт	47,226,800.00	46,593,122.00	633,678.00	98.66
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	579,138,400.00	562,253,793.08	16,884,606.92	97.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	540,125,300.00	529,815,068.08	10,310,231.92	98.09

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	-	3,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	722,500.00	582,462.00	140,038.00	80.62
210804	Тээврийн хэрэгслийн татвар	647,600.00	478,912.00	168,688.00	73.95
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	110,000.00	33,000.00	76.92
210807	Газрын төлбөр	34,000,000.00	31,267,351.00	2,732,649.00	91.96
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,844,800.00	1,008,000.00	10,836,800.00	8.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,844,800.00	1,008,000.00	10,836,800.00	8.51
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,862,000.00	8,857,131.00	4,869.00	99.95
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	4,644,000.00	4,642,131.00	1,869.00	99.96
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,644,000.00	4,642,131.00	1,869.00	99.96
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,218,000.00	4,215,000.00	3,000.00	99.93
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,218,000.00	4,215,000.00	3,000.00	99.93
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,833,310,800.00	3,585,455,184.23	247,855,615.77	93.53
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,833,310,800.00	3,585,455,184.23	247,855,615.77	93.53
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,833,310,800.00	3,585,455,184.23	247,855,615.77	93.53

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт		Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>312,938,354.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>312,938,354.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		269,250,711.14
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		33,226,399.47
210104	Урамшуулал		-
210105	Гэрээт ажлын хөлс		33,226,399.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		4,133,324.00
210201	Тэтгэврийн даатгал		4,133,324.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		3,689,579.00
210301	Гэрэл, цахилгаан		3,689,579.00
210302	Түлш, халаалт		-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		24,585,217.19
210401	Бичиг хэрэг		1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун		3,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		10,795,173.19
210404	Ном, хэвлэл		1,985,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,304,444.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		54,680,509.65
210601	Багаж, техник, хэрэгсэл		52,263,453.65
210604	Урсгал засвар		2,417,056.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		82,750,848.63
210702	Дотоод албан томилолт		82,750,848.63
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		66,184,833.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		66,184,833.20
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>43,687,643.55</b>
213305	Нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		43,687,643.55
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		312,938,354.69
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		312,938,354.69
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		62,636,175.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		250,302,179.69

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал С.Дэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд гарсан зардлын ангиллын дагуу ажил гүйлгээг бүртгэж байх, “Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг баримтлах, худалдан авалт хийхдээ хууль тогтоомж, журмын дагуу цахим төлбөрийн баримт бичгийг гүйлгээ хийх бүртээ авч байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Конфиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ШУА – ийн Одон орон, геофизикийн хүрээлэн нь одон орон, сансар судлал, геофизик, газар хөдлөл судлалын чиглэлээр онолын суурь судалгаа, судалгаа боловсруулалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн түвшинд гүйцэтгэх, судалгааны үр дүн, шинэ мэдлэг мэдээллээр Дэлхийн шинжлэх ухааны сан хөмрөгт хувь нэмрээ оруулах, нийгэмд шинэ мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх цогц үйл ажиллагааг явуулж байна.

Монгол орны газарзүйн байрлал, ажиглалт хэмжилт хийх таатай давуу нөхцлийг ашиглан сансар огторгуйн уудам, Дэлхийн гүн болон геомандалд болж буй үзэгдэл, хувьсал өөрчлөлтийн процессийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, одон орон, сансар судлал, геофизик, газар хөдлөл судлалын чиглэлээр суурь судалгаа явуулах нь тус хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагаа болно. Үүнд:

- Газар хөдлөл судлал
- Соронзон судлал
- Астрофизик судлал
- Астрометр судлал
- Астропарк үйл ажиллагаа

Тус хүрээлэн нь одон орон, геофизик, газар хөдлөл судлал, сансар судлалын шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилтыг нийгэмд таниулан сурталчилах, Хүрээлэнгийн суурь судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлж улс эх орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах туслах чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд захиргаа, санхүү, аж ахуйн үйл ажиллагааг чиглүүлэх, Хүрээлэн дээр хэрэгжиж буй судалгаа шинжилгээний ажлуудыг тасралтгүй хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, Төсвийн эд хөрөнгө, санхүүжилтыг хууль журмын дагуу үр ашигтай, оновчтой зарцуулах, орон нутаг дахь газар хөдлөлтийг бүртгэх 12

станцуудын дэд бүтэц, Одон орон судлах оргил, Хүрэлтогоот дахь соронзон оргил, Астропарк болон Хүрээлэнгийн төв байрны хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Өмнөх оны ТЕЗ-ийн аудитаар тус бодлогын баримт бичгийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн дагуу БШУС-ын 2020 оны А/20 дугаар тушаалаар шалгарсан зөвлөх үйлчилгээний компани 2021 оны 2 сард хүлээлгэн өгч шинэчилсэн НБББББ-ийг мөрдөхөөр болсон байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, Шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 5,804,416.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 116,088.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үед материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 6,641,454.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 132,629.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойллоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,389,617.6 мянган төгрөгөөр буюу 26 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	-	97,124.0	97,124.0
Авлага	15.8	43,136.3	43,120.6
Бараа материал	38,086.1	36,591.2	(1,494.9)
Үндсэн хөрөнгө	5,213,735.4	6,464,603.4	1,250,868.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,251,837.3</b>	<b>6,641,454.9</b>	<b>1,389,617.6</b>
Засгийн газрын оролцоо	5,251,837.3	6,641,454.9	1,389,617.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,251,837.3</b>	<b>6,641,454.9</b>	<b>1,389,617.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 97,124.0 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газар хоорондын гэрээний арилжааны банкин дахь дансны үлдсэн үлдэгдэл байна. Үлдэгдэл нь үлдэгдлийн баталгаагаар нотлогдож байна.

Авлага дансны үлдэгдэл 43,120.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд дуусаагүй байсан нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,464,603.4 мянган төгрөг болж 1,250,868.0 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 401 тоот тогтоолын дагуу 1,841,812.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө хасагдаж, дахин үнэлгээгээр 1,500,084.7 мянган төгрөг, БШУЯ-аас шилжиж ирсэн 13,891.6 мянган төгрөг, Засгийн газрын 243 тогтоолоор ШУА-ийн балансаас шилжиж ирсэн 160,057.7 мянган төгрөг, ТӨБЗГ-ын А-1/1137 дугаар зөвшөөрлөөр ШУА-ийн тэргүүлэгчдийн газрын үндсэн хөрөнгөөс шилжиж ирсэн 3,399.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын А-1/1822 дугаар хөрөнгө худалдан авах зөвшөөрлөөр 251,786.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын А-1/1137 дугаар зөвшөөрлөөр 49,772.0 мянган төгрөгийн хөрөнгө, ТӨБЗГ-ын 291 дугаар зөвшөөрлөөр 61,185.4 мянган төгрөгийн хөрөнгө тус тус акталж, тайлант онд 597,800.8 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,641,464.9 мянган төгрөг болж 1,389,617.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үр дүнгээс шалтгаалсан байна.

Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 4,429,466.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь Засгийн газар хоорондын гэрээгээр 2,084,713.2 мянган төгрөг орж ирсэн, Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 1,674,373.9 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 730,133.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 2,567,620.6 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин болон бараа ажил үйлчилгээний бусад зардлууд байна. Үүнээс 1,837,629.9 мянган төгрөг нь бараа ажил үйлчилгээний зардал буюу Засгийн газар хоорондын гэрээгээр зардал болно.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,470,016.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,470,016.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 636,705.3 мянган төгрөгөөр бууруулж, 3,833,310.8 мянган төгрөгөөр баталсан байна.



Шинжлэх ухааны академийн одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны төсвийн төслийн санал, боловсруулсан дүнгээр батлагдаж ирээгүй нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн зардлыг бууруулах, “Ковид 19” цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор төсвийн зардлыг өсгөхгүй байх зэрэг бодлогоос шалтгаалсан гэж үзэж байна. 2020 оны төсвийн төслийн саналд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд 131,162.9 мянган төгрөг, эрдэм шинжилгээний зардалд 90,470.0 мянган төгрөг тус тус тусгагдсан бөгөөд уг зардлууд нь дээд шатны төвлөрүүлэн захирагч байгууллагууд дээр хуваарилагдаж зарцуулалт нь хийгдэх байснаас гадна ашиглалттай холбоотой зардлаас 51,264.5 мянган төгрөг, хангамжийн зардал 64,460.4 мянган төгрөг, томилолтын зардал 59,025.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 353,129.3 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардал 135,456.1 мянган төгрөгөөр тус тус багасгаж батлагдсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 3,833,310.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,833,310.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,883,310.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,585,455.2 мянган төгрөгийг зарцуулж 247,855.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,585,455.2 мянган төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь нийт 8 ажилтан тэтгэвэрт гарсан, 6 хүн гадаадад суралцахаар явсан, 7 хүн жирэмсэн амаржсан болон хүүхдээ асрах чөлөө авсан, 2 хүн ажлаас чөлөөлөгдсөнөөс шалтгаалж 215,631.2 мянган төгрөгөөр цалингийн зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2020 оны тайлант жилд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 250,302.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 62,636.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 269,250.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 43,687.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 32 мэдээлэл, хугацаа нь болоогүй 4 мэдээлэл байгаа тул оруулаагүй байна.

2020 оны тайлант жилд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ нийт 48 ширхэг 440,150.6 мянган төгрөгийн гүйлгээ байгаагаас шилэн дансны цахим хуудсанд [/shilendans.gov.mn/](http://shilendans.gov.mn/) байршуулсан 48 ширхэг 440,150.6 мянган төгрөгийн гүйлгээ байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг 100% хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100
Нийт дүн	1	-	1	-	-	-	100

### 3.9 Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43,793.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 43,793.4 мянган төгрөгийн зөрчилд алдаа гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аудитын төлбөрийн өглөг зардал үүсгээгүй байсныг бүртгүүлэв

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансанд хугацаандаа оруулаагүй 32 мэдээлэлд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

1. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-т цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, иж бүрэн, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

#### Аудитын Зөвлөмж

Аудитаар илэрсэн 43,793.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Дараагийн аудитыг Үндэсний аудитын газар орохыг санал болгож байна.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Зардлын данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

- Шатахууны зардлыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны нормтой тулган шалгахад 7,184.5 мянган төгрөг илүү тооцоолсон байна.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэлдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэсэн заалтыг, “Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг” тус тус зөрчсөн байна.

###### 1.2. Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй зарцуулсан байх

###### 1.3. Өгсөн зөвлөмж:

Гарсан зардлын ангиллын дагуу ажил гүйлгээг бүртгэж байх, “Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг баримтлах

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

##### 2. Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал

###### 2.1. Илрүүлэлт:

Нийт 61 аж ахуйн нэгжтэй 869,582.0 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 722,260.3 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримт ирсэн, 36,608.9 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримтыг байгууллагаас гаргуулж аваагүй байна.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тасалбар болголт гэсэн батламж мэдэлдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 10.1-д “Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж , 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно”, 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

###### 2.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээ бүртгэж, тайлагнасан байх эрсдэлтэй.

###### 2.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ хууль тогтоомж, журмын дагуу цахим төлбөрийн баримт бичгийг гүйлгээ хийх бүртээ авч байх.

###### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж хуулийн хугацаанд мэдээлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			САГ-2021/95/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэн</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд аваагүй цахим төлбөрийн баримт	36,608.9	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	С.Дэмбэрэл З.Түвшинжаргал
2	Шилэн дансны мэдээлэл хугацаандаа оруулаагүй	-	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	С.Дэмбэрэл З.Түвшинжаргал
3	Шатахууны зардал илүү тооцсон	7,184.5	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	С.Дэмбэрэл З.Түвшинжаргал
<b>ДҮН</b>		<b>43,793.4</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 225/АО/60058

Улаанбаатар хот

САТ-0021/95/СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 32 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"; Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн Захирал С.Дэмбэрэл, нягтлан бодогч З.Түвшинжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
КОНФИДЕНС АУДИТ ХХК-ийн  
ЗАХИРАЛ

П. Ариунаа

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

П.АРИУНАА



